



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 07 сарын 30 өдөр

Дугаар А/51

Чингис хот

Биндэр сумын мэдээлэл зүйн иж бүрэн танхим, тохижилтын тоног төхөөрөмжийг хүлээн авах комисс томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Жагсаалт Батлах тухай" 388 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Биндэр сумын сургуулийн мэдээлэл зүйн иж бүрэн танхим, тохижилтын тоног төхөөрөмжийг хүлээн авах комиссыг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Д.Өнөрцэцэг	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Ц.Бат-Эрдэнэ	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
Гишүүд:	М.Ундрах	-Биндэр сумын ЕБС-ийн захирал
	Э.Оюунболор	-Биндэр сумын ЕБС-ийн мэдээлэл зүйн багш
	Ж.Байгалмаа	-Биндэр сумын ЕБС-ийн нийгмийн ажилтан

2. Ажлыг техникийн тодорхойлолтод заасан шаардлагын дагуу хүлээн авахыг комиссын дарга /Д.Өнөрцэцэг/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ТАНБААТАР